

**БНХАУ-ЫН ЦӨӨНХ ҮНДЭСТНИЙ ХЭЛНИЙ БОДЛОГЫН ТУХАЙ
ТОЙМЛОН ӨГҮҮЛЭХ НЬ (1949-1959)**

Э.Уриа

Түлхүүр үг: *Цөөнх үндэстнүүдийн хэл аялгуу, үсэг бичиг, төрийн бодлого ба хэрэгжилт*

БНХАУ нь 55 цөөнх үндэстэнтэй бөгөөд тэдгээрийн хүн ам нь Хятадын нийт хүн амын 8 хувийг эзэлж байна. Үндэстний цөөнхийн зарим нь дотроо хэд хэдэн аман аялгуутай бол зарим нь ганц хоёрхон аман аялгуутай. Үсэг бичгийн хувьд гэвэл, зарим нь хоёр болон түүнээс илүү үсэг бичиг хэрэглэдэг байхад зарим нь уулаас бичиг үсэггүй. Жишээлбэл, монгол үндэстэн түүхэндээ уйгуржин монгол, дөрвөлжин, тод, соёмбо зэрэг хэд хэдэн өөр бичиг хэрэглэж ирсэн бол Юннань мужийн Дай үндэстэн ч бас 4 зүйлийн үсэг хэрэглэж байжээ. БНХАУ нь үндэстнүүдийнхээ хэлний тэгш байдлыг чухалчилж, улсын хэмжээнд дагаж мөрдөх хууль дүрэмдээ нийт үндэстний хэл аялгуу ба үсэг бичгийн тухай асуудлыг адил тэгшээр тустан мөрдөж, хамгаалан хөгжүүлсээр иржээ.

БНХАУ байгуулагдсаны эхний арван жил (1949-1959) бол цөөнх үндэстнүүдийн хэл аялгуу, үсэг бичгийн тухай төрийн бодлого боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн цаг үе юм. Бид энэхүү өгүүлэлдээ 1949-1959 онд цөөнх үндэстнүүдийн хэл аялгуу, үсэг бичгийг хамгаалан хөгжүүлэх талаар БНХАУ-ын төр засгаас боловсруулан гаргасан хууль тогтоомж, дүрэм журмын талаар тоймлон өгүүлэхийг зорив.

БНХАУ бол олон үндэстэнтэй, олон хэлтэй, олон үсэг бичигтэй нэгдсэн улс юм. 1949 онд улс байгуулагдсаны эхний үед цөөнх үндэстний хүн ам нь тус улсын нийт хүн амын зөвхөн 6% -ийг эзэлж байсан боловч тэдгээрийн оршин суух газар нутаг нь нийт нутаг дэвсгэрийн 60 орчим хувийг эзэлж байжээ. Олон үндэстний Хятад улс нь байгуулагдсан цагаасаа эхлээд өөрийн бүрэлдэхүүн дэх цөөнх үндэстнүүдийн хэл аялгуу, уламжлалт үсэг бичгийг хадгалан хамгаалах, уламжлан хөгжүүлэх бодлогыг цаг үеийнхээ нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлагатайгаа уялдуулан зохицуулж, төрийн тодорхой бодлогоор удирдан чиглүүлсээр иржээ.

1. Хэлний бодлого гэж юу вэ?

Анх XX зууны 50-аад оны сүүлчээс эхлэн “хэлний төлөвлөлт”, “хэлний бодлого” гэсэн тусгай нэр томъёо хэрэглэгдэх болжээ. Тухайлбал, нийгэм хэл шинжлэлийн судалгааг үндэслэгч, Америкийн Колумб их сургуулийн профессор Уриел Вайнрайх /Uriel Weinreich/ (1926-1967) өөрийн зохион байгуулсан хэл шинжлэлийн онолын семинараа “Хэл шинжлэл ба хэлний төлөвлөлт” (Linguistics and Language Planning) хэмээн нэрлэсэн ажээ (1957:188-207). Өрнө дахины хэл шинжлэлчид XX зууны 80-аад оны сүүлч хүртэл “хэлний төлөвлөлт” (Language Planning) гэсэн нэр томъёог өргөн хэрэглэж байгаад 90-ээд оноос хойш “хэлний бодлого” (Language Policy) гэсэн нэр томъёог илүү хэрэглэх болсон бөгөөд тэдгээр хоёр нэр томъёоны хооронд утгын ялгаа байгаа эсэх талаар өөр өөр саналтай байдаг ажээ¹. Хэл шинжлэлчид хэлний бодлогын асуудлыг улам гүнзгийрүүлэн судалсаар иржээ. Америкийн

¹ Zhang Zhiguo. 2014. Analysis and Differentiation of Four LPLP Terms: Domestic and Foreign Perspectives.

хэл шинжлэлч Э. Хауген /Einar Haugen (1906-1994) “Орчин цагийн Норвег хэлний стандарт ба төлөвлөлт” гэсэн номдоо “Хэлний төлөвлөлт бол зөв бичлэгийн дүрэм, хэлний зүй, толь бичгийг дүрэмжүүлэх нэг зүйлийн үйл ажиллагаа, тухайлбал бичгийн болон ярианы хэлний хэрэглээг зохицуулна” (1959:8-21) гэж дурдаад цааш нь хэлний бодлогыг хэрэгжүүлэх нь хэлний хөгжлийн чиг баримжааг сонгох, тогтоох, хэлний бодлогыг хэрэгжүүлэх, дэлгэрүүлэх гэсэн дөрвөн үндсэн үе шаттай байна гэж үзсэн байна.

Германы хэл шинжлэлч, төрийн бодлогын онолч Хайнц Клосс (Heinz Kloss) (1904-1987) хэлний бодлогын онолыг боловсруулахдаа тухайн хэлнийхээ эзлэх байр суурийг тогтоох (status planning), хэлний элементийг төлөвлөх (corpus planning) гэсэн хоёр гол зорилтыг (1972:161) дэвшүүлсэн бол Америкийн нийгэм хэл шинжлэлийн эрдэмтэн Ж.Фишман (Joshua Fishman) (1926-2015) хэлний тухай бодлого нь тухайн хэлнийхээ тулгамдаж байгаа гол асуудлыг шийдвэрлэн хэрэгжүүлэхэд чиглэх ёстой гэж үзсэн байна.

Сүүлийн үед Р.Б.Каплан (Robert B. Kaplan), Р.Б.Балдауф (Richard B. Baldauf) нар “Хэлний төлөвлөлт хэрэглээнээс онол болглоо” гэсэн хамтын бүтээлдээ “хэлний төлөвлөлт бол хэсэг бүлэг хүмүүс ямар нэг байдлаар нийгмийн зарим хэсгийн хэлний хэрэглээг өөрчлөхөд хүргэдэг” (1997:3) гэж тэмдэглэсэн бол Израйлын Бар-Илан (Bar-Ilan) их сургуулийн профессор Б.Сполски (Bernard Spolsky) хэлний бодлого нь “хэлний хэрэглээ” (use of language), “хэлэнд итгэх итгэл буюу үзэл бодол” (language beliefs or ideology) болон хэлний төлөвлөлт гэсэн гурван үе шаттай гэж үзсэн байна (2018:10).

Хэлний төлөвлөлт гэдэг нь хэлний хэрэглээг зохистойгоор төлөвлөн чиглүүлэх бодит үйл ажиллагаа юм. Хятадын эрдэмтэн Чэн Жантай (Chen Zhangtai) “Хэлний төлөвлөлтийн судалгаа” гэсэн бүтээлдээ нийгмийн харилцаан дахь хэлний хэрэглээний асуудлыг шийдэхийн тул үсэг бичиг, бичгийн хэлний бодит хэрэглээг тодорхой бодлого зорилготойгоор зохицуулан удирдаж, тухайн хэлний нийгмийн үйлчилгээг хангана гэж дурдсан байна (2005:2).

Бид энэхүү өгүүлэлдээ БНХАУ-ын нам, төрөөс 1949-1959 оны хоорондох 10 жилийн хугацаанд цөөнх үндэстнүүдийн хэлний хэрэглээний талаар гаргасан хууль тогтоомжуудыг профессор Б.Сполскийн дэвшүүлсэн хэлний бодлогын онолтой уялдуулан авч үзсэн болно.

2. БНХАУ-д цөөнх үндэстний хэлний бодлогыг боловсруулж эхэлсэн нь

1949 онд БНХАУ байгуулагдсаны дараа цөөнх үндэстний хэл аялгуу болон үсэг бичгийг сурч судлах зэргээр хадгалан хөгжүүлэх ажлыг тодорхой дэс дараатайгаар хэрэгжүүлж эхэлжээ. Мөн үндэстний цөөнхийн муж орнуудад тус тусын хэл аялгуу, үсэг бичгийг судлах судалгааны төвүүдийг байгуулж, Хятадын Шинжлэх Ухааны Академийн харьяалалд багтаажээ.

Ер аливаа улсын хэлний бодлогын хамгийн чухал илэрхийлэл нь тухайн улсын засгийн газрын бодлогын хууль ёсны албан баримт бичиг юм. Эдүгээ дэлхийн 120 гаруй улс хэлний бодлогын тухай асуудлаа үндсэн хуульдаа тусгасан байдаг байна. Тэгвэл БНХАУ-ын дотор багтах олон үндэстнүүдийн хэлний тухай бодлого нь хамгийн анх 1949 онд гарсан “БНХАУ-ын Улс төрийн зөвлөгөөний хуралдааны нэгдсэн хөтөлбөр” хэмээх хууль, эрх зүйн баримт бичигт тусжээ. Тухайлбал, тус хөтөлбөрийн 53-р зүйлд “Үндэстний цөөнх бүр хэл, бичиг соёлоо хөгжүүлэх, ёс заншил, шашин шүтлэгээ өөрчлөх эрхтэй” гэж заасан байна. Түүний дараа 1954 онд батлагдсан “БНХАУ-ын Үндсэн Хууль”-ийн ерөнхий хөтөлбөрийн 3 дугаар зүйлд: “Үндэстэн бүхэн эх хэл, үсэг бичгээ хэрэглэх, хөгжүүлэх бүрэн эрхтэй” гэж заасан нь БНХАУ-ын дотор багтаж байгаа цөөнх үндэстнүүд өөр өөрийнхөө эх хэл, бичиг соёлыг уламжлан хөгжүүлэх боломжийг хуульчилсан хэрэг юм. Аливаа хуулийн заалтыг амьдрал дээр хэрэгжүүлэх гол хүчин зүйл нь тухайн асуудлыг эрхлэн гүйцэтгэх мэргэжлийн байгуулга байдаг. Тэгвэл БНХАУ-ын доторх олон үндэстний хэл аялгуу, үсэг бичгийн бодлогыг хуулийн дагуу хэрэгжүүлэх гол байгуулга нь үндэстний хэмжээний хэл бичгийн хэргийг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий “Үндэстний цөөнхийн хэл судлалын ажлын комисс”

юм. 1951 онд байгуулагдсан тус комисс анхныхаа хурлаас цөөнх үндэстний хэл бичгийг хөгжүүлэх 12 жилийн хэтийн төлөвлөгөөг боловсруулжээ. Тэрхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор 1954 онд “Үсэг бичиггүй үндэстэнд зориулсан үсэг бичиг зохиох тухай” шийдвэр гарч, 1956 онд “Үндэстний үсэг бичгийн цагаан толгойн хэлбэрийг сонгон тогтоох асуудал”-ын талаар тусгай ярилцах хурал зохион байгуулж, хятад хэлний авиа тэмдэглэх латин галиг үсгийн тогтолцоонд аль болохоор ойролцоо үсэг бичиг боловсруулахыг чухалчилж, улмаар 10 үндэстний хэл аялгууг тэмдэглэх 14 үсэг бичиг боловсруулан Жиньпо болон бусад зарим үндэстний цөөнхийн үсэг бичгийг анхлан боловсруулжээ. Түүнчлэн 1957 оноос эхлэн бүх шатны сургуульд хятад хэлний авиа тэмдэглэх латин цагаан үсгийг зааж сургах тухай мэдэгдэл гаргажээ.

Мөн 1955 онд дээр дурдсан хэтийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Бээжин хотноо цөөнх үндэстний хэл аялгууг судлах анхдугаар зөвлөгөөн болж, Хятад улсын доторх олон үндэстнүүдийн хэл аялгууг байцаан судлах тухай тогтоол гаргаж, юуны өмнө Хятадын Шинжлэх Ухааны Академиас цөөнх үндэстний хэл аялгууг байцаан судлах тусгай арга зүйг боловсруулан, улмаар тэрхүү арга зүйгээр цөөнхийн хэл аялгуунуудыг судлах 700 гаруй хүний бүрэлдэхүүнтэй томоохон баг бэлтгэжээ. Тус багт Хятадын Шинжлэх Ухааны Академийн холбогдох хүрээлэнгийн судлаачдаас гадна муж, орны үндэстний их, дээд сургуулиудын хэл судлалын тэнхимийн багш нар, цөөнхийн хэл судлах эрдэм шинжилгээний байгууллагуудын эрдэмтэн судлаачдыг багтаажээ. Тэдгээр судлаачид долоон баг болон хуваагдаж, 1956 оноос эхлэн Гуанси, Гуандун, Гүйжоу, Юннань, Сычуань, Хунан, Хүбэй, Хөхнуур, Ганьсу, Хармөрөн, Шинжаан, Өвөр Монгол зэрэг муж орнуудаар 42 үндэстний хэл аялгууны судалгаа хийсэн байна. Монгол хэл аялгуунуудын судалгааны хувьд гэвэл, Өвөр Монголын нутаг дэвсгэрт оршин суудаг монгол аман аялгуунууд болон Ганьсу, Хөхнуур, Шинжаан дахь Монгол, Дуншиан, Баоан, Зүүн-Уйгур зэрэг хэлнүүдийн авианы тогтолцоо, хэлзүй, үгсийн сангийн бүрэлдхүүнийг багтаасан өргөн хүрээтэй судалгаа хийсэн байна. Хятад дахь олон үндэстний хэл аялгууг байцаан судлах ажлын явцыг хянаж, үр дүнг нь дээшлүүлэх, мэргэжлийн зөвлөгөө өгөх зорилгоор Бээжин хот дахь Төвийн Үндэстний Их Сургуулийн дэргэд “Үндэстний хэлний хүрээлэн” байгуулжээ.

3. Дүгнэлт

Хэлний бодлогын хүрээнд аль нэгэн хэл аялгуу, үсэг бичгийн холбогдолтой асуудлыг хэн нэгэн хувь хүн, нийгмийн тодорхой бүлгээс санаачилж болох бөгөөд түүнийг зохих эрх бүхий төрийн дээд байгуулга хянан үзэж, батламжлах ёстой. БНХАУ-ын хувьд 1949-1959 онд үндэстний цөөнхийн хэл аялгууг хадгалан хөгжүүлэх, уламжлалт үсэг бичгийг нь үргэлжлүүлэн хэрэглэх, зарим үндэстний үсэг бичгийг шинээр боловсруулан зохиох зэрэг өргөн хүрээтэй ажил хэрэгжүүлсэн нь үндэстэн бүр хэл, соёлоо хөгжүүлэн үндэстнийхээ онцлог шинжийг хадгалж, тэдний боловсрол мэдлэг, нийгмийн идэвх оролцоог дээшлүүлэх үндэс суурийг тавьсан нааштай сайхан эхлэл нь болсон билээ.

Abstract

China has 55 ethnic minorities, accounting for 8% of China's total population. Some ethnic minorities have several dialects, while others have only one or two dialects. As for scripts, some minorities use two or more, while others have no script at the beginning. For example, Mongols have historically used a number of different scripts, including Uighur-Mongolian, Todo, and Soyombo, etc. While Dai ethnic minority of Yunnan Province of China has also used four different scripts. The People's Republic of China emphasizes the language equality of the nationalities, and has consistently upheld and protected the dialects and scripts of all minorities in its national laws and regulations.

The first decade of the founding of the People's Republic of China (1949-1959) was the beginning of the development and implementation of state policies on minority dialects and scripts. In this article, we provide an overview of the laws and regulations formulated and implemented by the Government of the People's Republic of China in 1949-1959 for the protection and development of minority dialects and scripts.

Keywords: *The dialects and scripts of ethnic minority; China's state policies on minority dialects and scripts*

Номзүй

Bernard Spolsky. *Хэлний бодлого-нийгэм хэл шинжлэлийн чухал сэдэв* (Жан Жыгө хятад хэлээр орчуулав). 7 х.

Chen Zhangtai. 2005. *Хэлний төлөвлөлтийн судлагаа*. The Commercial Press. х.2
Construction and Reconstruction in Language Planning: Ivar Aasen's Grammar. Word. 21:2, 188-207

Kaplan Robert B. & Baldauf Richard B. 1997. *Language Planning from Practice to Theory*.
Clevedon: Multilingual Matters Ltd. х. 3

Language Planning. Theory and Practice. The Ecology of Language. p. 287

Linguistics and Language Planning, 'The Ecology of Language', Stanford University Press, 1972.
p. 161

Liu Haitao. 2004. *Хэлний бодлого ба хэл төлөвлөлт: Ухагдахууны хувьслаас салбарын хөгжилт хүртэл*. Бээжин.

Planning for a Standard Language in Modern Norway, Anthropological Linguistics, 1:3, 1959, 8-21

Zhang Zhiguo. 2014. *Analysis and Differentiation of Four LPLP Terms: Domestic and Foreign Perspectives*.

Ван Айюнь. *ХКН болон шинээр байгуулагдсан БНХАУ-ын хэл үсэг бичгийн бодлого* (1949-1958).

Ли Айлиань. *БНХАУ байгуулагдсанаас хойш Хятадын цөөнхийн хэлний бодлогын тойм*. Өвөр монголын өдрийн сонин (1952-1958).

Хичээлт. 1999. *Нийгэм хэл шинжлэл хэлний төрийн бодлого*. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

Хуан Шин. 2019. *Хятадын үндэстний хэл үсэг бичгийн 70 жил*. Chinese Journal of Language Policy and Planning.